



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/599

Алтай хот

**Үзэсгэлэн худалдаа зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч болон малчдыг дэмжиж, тэдний үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнийг зах зээлд таниулан сурталчилах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Алтай түншлэл-2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 10 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд Алтай хотод зохион байгуулсугай.

2.Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг гарган, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, чанартай зохион байгуулж, үр дүнг танилцуулж, нийтэд мэдээлж ажиллахыг ажлын хэсэг (Г.Чинбат)-т үүрэг болгосугай.

3.Газар тариалан, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үзэсгэлэн худалдаанд өргөнөөр оролцуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын ~~2008~~ оны
09 дугаар сарын 23-ны өдрийн 1599 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДИСА0042

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Чинбат	(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Г.Хурцгэрэл	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	С.Баярмаа	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Т.Сүхбаатар	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Т.Эрхэмбаяр	(Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн захирал)
	Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
	Ж.Уранчимэг	(Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Т.Мөнхнасан	(Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга)
	С.Нинжбадам	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
	Э.Танхилмаа	(Мэргэжлийн хяналтын газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч)
	Г.Энхбаяр	(аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)
	А.Алтанхуяг	(Есөнбулаг сумын Засаг дарга) (Сумын Засаг дарга нар)
Нарийн бичгийн дарга:	Р.Цэнд-Аюуш	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)